



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 728

Улаанбаатар хот

Тогтоолын заалт хүчингүй болгох тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 474 дүгээр тогтоолын хоёрдугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 33-т “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг 1,592,250,000 төгрөг гэж тогтоосныг хэвээр мөрдсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ